“МӨРӨН МАЙНИНГ” ХХК-ИЙН (ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ, БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМД) ҮЗҮҮРТ ТАЛБАЙ ДАХЬ БИЛЭГХИЙН САЙРЫН “ЖАЛГА-1”, “ЖАЛГА-2” ДУНД, ДООД БОЛОН ШААЗГАЙТ ДЭНЖ-1,2 АЛТНЫ ШОРООН ОРД АЛТНЫ ШОРООН ОРДЫН

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/ MV- 022144, РД 6613713/

2025 он

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 3

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл 3

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 25

2.1 Байгаль орчны төлөв байдал 25

2.2 Нийгэм эдийн засгийн төлөв байдал 32

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 35

3.1 Төслийн гадаад болон дотоод овоолго барьж байгуулах үеийн гол нөлөөлөл 37

3.2 Гадаад болон дотоод овоолго байгуулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл 37

3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл 38

3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл 40

3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл 40

3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл 40

3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл 41

3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл 41

3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл 41

3.11 Хуримтлагдах нөлөөлөл 42

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ 44

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 47

ЗУРГАА.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 52

ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 55

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 55

АРАВ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 56

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 60

АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 63

АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 64

ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл, бичиг баримтын бүрдэл.....3
Хүснэгт 2. Ашигт малтмалын MV-022144 дугаартай тусгай зөвшөөрөлтэй талбайн захын цэгүүдийн солбилцол.....7
Хүснэгт 12. Тоног төхөөрөмжийн жагсаалт.....12
Хүснэгт 13. Үйлдвэрийн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа.....13
Хүснэгт 14.Уурхайн нээлтийн ажлын хэмжээ.....15
Хүснэгт 15. Угаан баяжуулах цехийн технологийн усны хэрэглээ.....19
Хүснэгт 16. Ахуйн ундны усны тооцоо.....19
Хүснэгт 17. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ.....20
Хүснэгт 18. Усны нийт хэрэглээний тооцоо.....21
Хүснэгт 13. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа.....35
Хүснэгт 14. Гол нөлөөллийн дүн шинжилгээ.....35
Хүснэгт 15. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ.....39
Хүснэгт 16. Автомашины утааны бүрдэл найрлага.....39
Хүснэгт 17. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл.....42
Хүснэгт 18. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн нотолгоо.....47

ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн сансарын зураг.....8
Зураг 2. Төслийн талбайн байрзүйн зураглал.....9
Зураг 3. Тусгай зөвшөөрлийн талбайн засаг захиргааны зураглал.....10
Зураг 5. Төслийн MY-022144 тусгай зөвшөөрлийн хил доторхи Жалга-3, Жалга-2 нөөцийн блокууд байрласан ерөнхий дэвсгэр зураглал.....11
Зураг 15. Уурхайн кемпийн харагдах байдал.....16
Зураг 16. Худгийн байршил.....18
Зураг 7. Уурхайн кемпийн харагдах байдал.....23
Зураг 8. Төслийн талбайн кемпийн ерөнхий төрх -№2 2023.07.24.....24
Зураг 9. Төслийн талбайн цуглах цэг №3 2023.07.24.....24
Зураг 12. Хогийн савны төрөл.....59

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

“Мөрөн майнинг” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV-022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлийг АМГТХЭГ-ын даргын 2022 оны 07-р сарын 06-ны өдрийн шийдвэрийн дагуу 30 жилийн хугацаатай эзэмшиж байна.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл, бичиг баримтын бүрдэл

Нэг. Төслийн бичиг баримтын бүрдэл		
1.1	Тусгай зөвшөөрөл:	“Мөрөн майнинг” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан орших MV- 022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлийг АМГТХЭГ-ын даргын 2022 оны 07-р сарын 06-ны өдрийн шийдвэрээр олгосон байна.
1.2	Археологийн дүгнэлт	ШУА Археологийн хүрээлэнгийн 2021 оны 11 сарын 10-ны өдрийн №01/247 дүгнэлт
1.3	Палентлогийн дүгнэлт	ШУА Палентлогийн хүрээлэнгийн 2021 оны 10 сарын 19-ны өдрийн №Т/93 дүгнэлт
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	“Үзүүрт”ашиглалтын талбай дахь Билэгхийн сайрын“Жалга-1”, “Жалга-2” дунд , доод болон Шаазгайт дэнж-1,2 алтны шороон орд
2.2	Төслийн байршил	 Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт дамнан байрладаг.

		
2.3	Зорилго	“Үзүүрт”ашиглалтын талбай дахь Билэгхийн сайрын“Жалга-1”, “Жалга-2” дунд , доод болон Шаазгайт дэнж-1,2 алтны шороон ордын нөөцийн ил аргаар ашиглах гол зорилго нь ажилчдыг ажлын байраар хангах, алт олборлон эдийн засгийн эргэлтэд оруулах, Монгол улсын валютын нөөц бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулахад оршино. -Улс, *Орон нутгийн төсөвт 2023.9 сая төгрөгийн орлого оруулах* *- Ажлын байрны тоо жилд дундажаар 130 хүний шууд ажлын байр бий болгоно.* *- Орон нутгаас нийт ажилчдын 30 хувьд нь мэргэшүүлэн ажилд авна.*
2.4	Төслийн ерөнхий төлөвлөгөө, ажиллах хуваарь	***Уурхайн ажлын горим*** Тус орд нь улирлын чанартай ажиллах бөгөөд 5 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 9-р сарын 10-г дуустал 5-н сарын хугацаатай ажиллана. Ил уурхайн процессыг хэрэгжүүлэхэд ашиглах тоног төхөөрөмжийн мөрдөх ажлын горим нь хоногт 2 ээлжээр, нэг ээлжид 10 цаг байна. Уурхайн ажлын горимыг жилд амрах баяр ёслолын хоног, цаг агаарын хүндрэлийн хоног, мөн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хоногуудыг тус тус оруулсан байна. **Ажилчдын орон тоо, цалингийн зардал (сан)** Ажиллах хугацаанд ажиллагсдын сарын дундаж цалин илүү цаг тооцсоноор 2150 мянган төгрөг болж байгаа. Уурхайн жилийн үндсэн цалингийн фонд 1248.4 сая төгрөг байна.

		Байгууллага нийгмийн даатгалын шимтгэлд 33.81 сая төгрөг жилд төлнө. Ажиллагсдын цалингаас 12.86 сая төгрөгийг хүн амын орлогын албан татварт суутгаж, төсөвт төлнө. Ил уурхайн хүчин чадлыг харгалзан **авто-тээвэртэй гадаад, дотоод овоолготой** ашиглалтын системийг сонгон авсан байна.
2.5	Хүчин чадал	***Төслийн хүчин чадал, орд ашиглалтын хугацаа*** Уурхайн хүчин чадал “Үзүүрт” нэртэй алтны шороон ордыг захиалагчийн техникийн даалгавар, уул техникийн нөхцөл, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэгт үндэслэн жилийн хүчин чадал нь 217.0 мян.м3 элс, нийт 2 жилийн хугацаанд ашиглана. Баяжуулах цехийн хүчин чадал: Угаан баяжуулах цех нь зөвхөн улирлын чанартай байдлаар буюу 5-10 р сард ажиллах ба нийт 111 хоног 10 цагийн 2 ээлжээр ажиллах ба угаан баяжуулах цехийн цагийн хүчин чадал 160 м3 / байна.
2.6	Төслийн хог хаягдал	**Хатуу хог хаягдал:** Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор жилд 13,2 тн орчим хаягдал гарах бөгөөд харъяа сум багийн холбогдох /ТҮК/-тэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна. Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана. Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна. **Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Аюултай хог хаягдлын жагсаалт** *Доорхи зургийн дагуу ялгаж хаях шаардлагатай*  **Шингэн хог хаягдал:**

		Нийт 130 ажилтантай гэж үзвэл хоногт 10,4м^3, жилд амралт баяр ёслолын өдрийн хасаад 118 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 1227,2 м^3/жил болно. Технологийн усны хэрэглээнд нийт 1723.28 мян.тонн усыг хэрэглэхээр тооцсон байна.[1] Соруулдаг бохирын ёмкостой болно. **Хийн хаягдал:** Үйлдвэрийн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна. Уурхай ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт **120.81 тонн** дизель түлш зарцуулахад хөө – 1.87 тн, CO-0.00001208 тн, нүүрстөрөгч-3.6243 г, NO_2–0.00005927 тн, SO_2-0.00000242 тн, бензопирин-0.000474 тн буюу нийтдээ 1.871 тн хорт хий ялгарахаар байна.
2.7	Ариун цэврийн байгууламж	Ажилчдын гэр кемп дотор төвлөрсөн ариун цэврийн байгууламжтай бөгөөд байгаль орчин, ариун цэврийн цаасыг зөв зохистой ашиглах, хувийн ариун цэвэр сахих соёлын тухай санамжуудыг байрлуулж ба экологийн боловсролын булан бий болгосон.
2.8	Усан хангамж	Тус уурхай нь өөрийн гүний худагтай.
2.9	Цахилгаан хангамж	**Дизель генератор:** Denyo DCA-220SPK3 220 кВт 1ш, Denyo DCA-180SPK3 125 кВт 1ш,
2.1	Дулаан хангамж	Улирлын чанартай ажиллах тул дулаан хангамж шаардлагагүй.

Судалгааны объектын товч танилцуулга

Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон орд нь III бүлэгт хамаарах бөгөөд ордын хэмжээнд тогтоогдсон алтны боломжтой нөөц С зэрэглэлийн химийн цэврээр нийт 10.46 кг, В зэрэглэлийн химийн цэврээр нийт 10.36 кг байна. Ордын хэмжээнд хөрсний дундаж зузаан 1.43 м, элсний дундаж зузаан 0.43 м, дундаж агуулга 167 мг/м3 болно.

Ил уурхайн ашиглалтын үйл ажиллагааны явцад үйлдвэрлэлийн нөөцөөр нийт 211.8 мян.м3 хөрс хуулалт, 88.7 мян.м3 элс олборлоно. Гадаад овоолгод 33.61 мян.м3 шимт хөрс, 1.8 мян.м3 хөрс гадаад овоолгод байрших ба үлдсэн 210.0 мян.м3 хөрс дотоод овоолгод байршуулахаар тооцсон болно.

Ил уурхайн хүчин чадлыг харгалзан авто-тээвэртэй гадаад, дотоод овоолготой ашиглалтын системийг сонгон авлаа.

ТЭЗҮ үнэлгээгээр: Тус төсөл нь зуны улирлын 5 сар ажиллах ба уурхай, угаах төхөөрөмжинд нийтдээ хүн ажиллах юм. Эхний жилд 4 сарын 1 нээс нийт 33 хүн ажилчид авах ба оны сүүлийн 3-4 сард сул зогсоно гэж тооцоолов.

1.2 Төслийн байршил

Судалгааны талбай нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын төвөөс урагш 19 км, Баянхонгор аймгийн Өлзийт сумын төвөөс зүүн урагш 46 км-т оршино. “Үзүүрт” нэртэй

[1] *ТЭЗҮ 90-р хуу*

MV-022144 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 1027.27 га бүхий талбайг хамран байр зүйн зургийн L-47-83 хавтгайд байрлана.

Ашиглалтын нийт талбайн 95 хувь нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутаг дэвсгэрт, 5 хувь нь Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутаг дэвсгэрт тус тус хамааргдаж байна.

Газрын байршил орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 2 км-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105 : 2001 стандартын шаардлага хангаж байна.

Хүснэгт 2. Ашигт малтмалын MV-022144 дугаартай тусгай зөвшөөрөлтэй талбайн захын цэгүүдийн солбилцол

№	Өргөрөг	Уртраг
	x	y
1	101° 18' 58.29"	45° 49' 40"
2	101° 18' 12.82"	45° 49' 40"
3	101° 18' 12.82"	45° 49' 14.3"
4	101° 18' 35.69"	45° 49' 14.3"
5	101° 18' 35.69"	45° 48' 58.19"
6	101° 18' 59"	45° 48' 58.19"
7	101° 18' 59"	45° 48' 42"
8	101° 18' 12"	45° 48' 42"
9	101° 18' 12"	45° 48' 10"
10	101° 19' 39"	45° 48' 10"
11	101° 19' 39"	45° 47' 36.65"
12	101° 18' 46.1"	45° 47' 36.65"
13	101° 18' 46.1"	45° 47' 16"
14	101° 20' 12"	45° 47' 16"
15	101° 20' 12"	45° 48' 11"
16	101° 21' 5"	45° 48' 11"
17	101° 21' 5"	45° 47' 46"
18	101° 21' 57"	45° 47' 46"
19	101° 21' 57"	45° 47' 27"
20	101° 22' 40"	45° 47' 27"
21	101° 22' 40"	45° 48' 0"
22	101° 22' 31"	45° 48' 0"
23	101° 22' 31"	45° 48' 19"
24	101° 20' 28.5"	45° 48' 19"
25	101° 20' 28.5"	45° 48' 57"
26	101° 19' 52"	45° 48' 57"
27	101° 19' 52"	45° 49' 20"
28	101° 18' 58.29"	45° 49' 20"



Зураг 1. Төслийн талбайн сансарын зураг

Зураг 2. Төслийн талбайн байрзүйн зураглал



Зураг 3. Тусгай зөвшөөрлийн талбайн засаг захиргааны зураглал



Зураг 4. Төслийн MY-022144 тусгай зөвшөөрлийн хил доторхи Жалга-3, Жалга-2 нөөцийн блокууд байрласан ерөнхий дэвсгэр зураглал

Төслийн талбайн байршил, онцлог. Судалгааны талбай нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын төвөөс урагш 19 км, Баянхонгор аймгийн Өлзийт сумын төвөөс зүүн урагш 46 км-т оршино. Талбайн хэмжээ нь 1027.27 га.

Одоогоор төслийн талбайд үйл ажиллагаа явуулаагүй байна. Цаашид тус төслийн талбайд хүний үйл ажиллагаа болон техник технологийн нөлөөгөөр газрын эвдрэл ихсэж болзошгүй тул төслийн бүх шатанд анхаарч ажиллах шаардлагатай. Тээвэрлэлтийн үед тогтоосон маршрутын дагуу явах, ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулахыг зөвлөж байна.

1.3 Ил уурхайн хүчин чадал

Хайгуулын ажлаар ордын нөөцийг “Билгэхийн сайрын жалга-1” боломжтой С зэрэглэлээр 4.16 кг, ” Билгэхийн сайрын жалга-2” дунд хэсэг боломжтой С зэрэглэлээр 10.81 кг, ” Билгэхийн сайрын жалга-2” доод хэсэг боломжтой С зэрэглэлээр 9.26 кг, ”Шаазгайт дэнж” хэсэгт бодитой В зэрэглэлээр 9.07 кг, боломжтой С зэрэглэлээр 1.55 кг, ”Урд дэнж-1” хэсэгт бодитой В зэрэглэлээр 7.83 кг, боломжтой С зэрэглэлээр 0.98 кг, ”Урд дэнж жалга” хэсэгт бодитой В зэрэглэлээр 0.75 кг, боломжтой С зэрэглэлээр 0.03 кг, ”Урд дэнж-2” хэсэгт бодитой В зэрэглэлээр 5.53 кг, боломжтой С зэрэглэлээр 0.5 кг, нийт бодитой В зэрэглэлээр 23.19 кг /хими цэвэр/, боломжтой С зэрэглэлээр 27.27 кг /хими цэвэр/, В+С зэрэглэлээр 50.46 кг /хими цэвэр/ тогтоосон байна.

Уулын ажлын календарчилсан төлөвлөлт

Үзүүртийн алтны шороон ордын олборлолт нь 2 жил үргэлжлэх ба ашиглалтын үед нийт 1053.3 мян.м3 хөрс хуулж 435.5 мян.м3 элс олборлоно. Хөрс хуулалтын дундаж коэффициент 2.42 м3/м3 байна.

1.4 Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа, урьд нь ашиглагдаж байсан тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлана.

Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр, марк	Үзүүлэлт	Ашиглалтын жил	Өмчлөлийн хэлбэр
1	Экскаватор – Liebherr R-924	1.25 м.куб	2	
2	Автосамосвал – North benz 2527k	20 тн	4	

3	Бульдозер – Shantui SD23	6.5 м.куб	1	Өөрийн
4	Утгуурт ачигч – XGMA-XG955H	3.0 м.куб	1	
5	Усны машин – Майти	5 тн	1	
6	Түлшний машин – Майти	5 тн	1	

1.5 Ил уурхайн ажиллах горим, ашиглах хугацаа, цалингийн сан

Тус орд нь улирлын чанартай ажиллах бөгөөд 5 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 9-р сарын 10-г дуустал 5-н сарын хугацаатай ажиллана. Ил уурхайн процессыг хэрэгжүүлэхэд ашиглах тоног төхөөрөмжийн мөрдөх ажлын горим нь хоногт 2 ээлжээр, нэг ээлжид 10 цаг байна. Үүнээс:

Ээлжид ноогдох үндсэн ажил 10 цаг

Ээлж хоорондын тоног төхөөрөмжийн үзлэг, үйлчилгээний 2 цаг

Ээлжид ноогдох бүтээлт цаг 8 цаг

Хүснэгт 4. Үйлдвэрийн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа

Үзүүлэлт	Нэгж	I жил	II жил
Уурхайн жилд ажиллах хонгийн тоо			
Календарь хоногийн тоо	хоног	118	118
Баяр ёслол хоног тоо	хон/жил	8	8
Уулын бэлтгэл ажил	хон/жил	5	3
Цаг агаарын саатал, сул зогсолт	хон/жил	3	3
Засвар үйлчилгээ	хон/жил	8	4
Жилд ажиллах бодит хоног	хон/жил	94	94
Уурхайн жилд ажиллах цаг	цаг/жил	1504	1504
Ээлжийн зохион байгуулалт			
Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж/хон	2	2

Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг/ээлж	10	10
Засвар үйлчилгээний цаг			
Төлөвлөгөөт их засвар үйлчилгээ	хон/жил	2	2
Урсгал засвар үйлчилгээ	хон/жил	2	2
Нийт засвар үйлчилгээ	хон/жил	4	4
Техникийн бэлэн байдал	%	85	85
Цаг агаарын саатал	хон/жил	3	3
Ээлжийн цаг ашиглалт			
Үзлэгийн хугацаа	мин/ээлж	10	10
Ээлж солих хугацаа	мин/ээлж	20	20
Хоолны цаг	мин/ээлж	50	50
Ажлын талбар цэвэрлэх, байр засах, шилжилт хийх хугацаа	мин/ээлж	20	20
Түлш цэнэглэх	мин/ээлж	20	20
Бүтээлгүй ажиллах нийт хугацаа	цаг/ээлж	2	2
Ээлжид бүтээлтэй ажиллах цаг	цаг/ээлж	8	8
Хоногт цаг ашиглалт	цаг/хон	10	10
Цаг ашиглалт коэффициент	-	0.8	0.8
Уурхайн тоног төхөөрөмжүүдийн жилд ажиллах цаг			
Ээлжид хөдөлгүүр унтраах хугацаа	цаг/ээлж	1.5	1.5
Ээлжид хөдөлгүүр ажиллах хугацаа	цаг/ээлж	8.5	8.5
Хөдөлгүүрийн ашиглалтын коэффициент		0.85	0.85

1.6 Орд нээх ба ашиглах тооцоо

Ил уурхайн төлөвлөлт.Ил уурхайн төлөвлөлтийг ил уурхайн хүрээн дэх нөөцөд тулгуурлан хийлээ. Олборлолтын төлөвлөгөөг боловсруулахдаа блокуудыг нэг талаас нь хөөх маягаар уулын ажлыг явуулахаар тооцсон.

Ашиглалтын технологи. Үзүүрт нэртэй талбайн “Жалга-2”, “Жалга-3” алтны шороон ордын уул техникийн нөхцөл үзүүлэлтээс харахад тус орд нь хөрсний хурдас нь том бул чулуу, цэвдэгшил байхгүй, уул техникийн нөхцөл сайн, гидрогеологийн нөхцөл энгийн тогтоцтой, хамгийн ихдээ 3.0 метр хүртэлх ухаш үүснэ. Ашигт давхарга нь босоо байрлалаараа улирлын хөлдөлтөнд бараг ордоггүй учир уул-геологийн хувьд олборлолтын явцад онцын хүндрэл үүсэхгүй. Тиймээс уурхайг бусад шороон ордын жишгээр ил аргаар тээвэртэй-гадаад болон дотоод овоолго хослосон ил уурхайн ашиглалтын системээр ашиглахаар сонголоо.

Уурхайн нээлт: Эхний сард хөрс хуулалтын ажил харьцангуй бага ашиглахад тээврийн зай хамгийн бага байх буюу Жалга-2 ордын С-2 блокоос эхлэн зүүн урдаас баруун хойш чиглэлд налуу траншей амаар нээж ашиглана. Үзүүртийн алтны шороон ордын Жалга-2 ордын С-2 блокоос эхлэн нээж 21С, 22С гэх блокуудыг олборлох замаар баруунаас, зүүн, зүүн хойд тал руу ажлын фронтын чиглэл давших байдлаар өрнөнө. Нээгч траншейн ёроолын өргөн 10м, өндөр 3м, траншейн замын налуу 6 град буюу 105 промиль, хажуугийн өнцөг 55 градус, урт 30м, эзлэхүүн 375 м3 байна.

Үржил шимт хөрс хуулалт: Ордын ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрсийг Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу 0.2 метр зузаантайгаар экскаватор, автосамосвалын тусламжтай уурхайн хүрээний гадна 30-40 м-ийн зайд зөөн овоолж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглана. Шимт хөрсний овоолгын өндөр нь 2.0 м байх бөгөөд хажуугийн тогтворжилтын өнцөг нь 35 градус байна. Шимт хөрсийг хуурай сэрүүний улиралд хуулах нь тохиромжтой бөгөөд овоолгыг аль болох нөмөр газар хийх ба тийм боломжгүй тохиолдолд шимт хөрсний овоолгыг сууж дагтарштал нь тусгай зориулалтын торон хучилт хийж салхи шуурганд хийсэхээс сэргийлэх болон ургамалжуулж болно. Шимт хөрсийг уурхайн үндсэн хөрс хуулалтын ажлаас өмнө хуулж овоолсон байна.

Уурхайн бэлтгэл ажил: Бэлтгэл ажлын хүрээнд уурхайн шимт хөрсийг хуулж бэлдэх өмнөх олборлолтын үед ашиглаж байсан угаах цехийн тунаах нуур, хаягдлын далан зэргийг сэргээн ашиглах ба угаах төхөөрөмжийн талбайг бэлтгэх, баяжуулах цехийн элсний нөөцийг бэлтгэх, далан болон баяжуулах цехийн талбайг сэргээн засах угсрах зэрэг ажлууд орно.

Хүснэгт 5.Уурхайн нээлтийн ажлын хэмжээ

Хийгдэх ажил	Хэмжээ,м3
Шимт хөрс хуулалт	2153.4
Хөрс хуулалт	3269.7

Траншей нэвтрэх	320
Нийт	5,743.2

Хөрс хуулалтын ажил: Ил уурхайг нээх буюу эхлэх үед хөрсний чулуулгийг экскаватор - автосомасвалын хослолоор олборлолтын талбайн гадна гадаад овоолго хийнэ. Ийнхүү хөрс хуулалт болон элс олборлолтыг явуулж тухайн хэсэгт тодорхой хоосон орон зай гаргаж, дараагийн олборлолтын блокийг гарсан орон зайд экскаватор-автосомасвалын хослолоор зөөвөрлөн дотоод овоолго хийх замаар хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэнэ. Хөрс хуулалтын ажлын доголын өндөр 5 м байна. Хөрсний гадаад овоолгын доголын өндөр 2-10 м, доголын налуугийн өнцөг 35 градус байна.

Элс олборлолтын ажил: Элс олборлолтын догол, мөргөцгийн өндөр нь мөн элсний давхаргын зузаанаас шалтгаалж уурхайн дунджаар 1.1 м байна. Олборлолтын ажлыг экскаватор, автосамосвалын хослолоор ухаж ачин тээвэрлэж баяжуулах төхөөрөмжийн дэргэд байрлах элсний түр овоолгод овоолно.

1.7 Уурхайн дэд бүтэц

Зураг 5. Уурхайн кемпийн харагдах байдал

1.7.1 Цахилгаан хангамж

Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг зөөврийн дизель цахилгаан үүсгүүр ашиглан цахилгаан эрчим хүчээр хангана. Тус уурхайн цахилгааны гол хэрэглэгч нь баяжуулах цех, засварын газар, кемп байна.

1.7.2 Дулаан хангамж

Улирлын чанартай ажиллах тул дулаан хангамж шаардлагагүй.

1.7.3 Усан хангамж

“Үзүүрт” нэртэй тусгай зөвшөөрлийн талбайн Билэгхийн сайрын “Жалга-1”, “Жалга-2” дунд, доод болон Шаазгайт дэнж-1,2 алтны шороон орд талбайд ордууд нь гарал үүсэл, байршил, хэлбэр хэмжээ, ашигт давхаргын тогтвортой байдал, ашигт эрдсийн тархалтын онцлог зэрэг геологийн тогтцын нийлмэл байдлаар алтны шороон ордын III бүлгийн ордод хамаарагдаж байна.

Тухайлбал нөөцийн хувьд бага хэмжээний, ашигт эрдсийн тархалт жигд бус, ашигт давхаргын зузаан болон өргөн нь тогтвортой бус, нарийн туузлаг ашигт давхаргатай, баян ба харьцангуй ядуу агуулгатай хэсэг ээлж дараалсан бүрдэлтэй, цөөнгүй тохиолдолд ашигт эрдсийн ихэнх хэсэг суурь чулуулгийн ан цавд хуримтлагдсан байна.

2023 онд хайгуулыг шурф нэвтрэлтийн аргаар 200х20м-ийн торын нягтралаар гүйцэтгэсэн бөгөөд “Жалга-1” талбайд хайгуулын 10 шугамд 0.6-3.8 м-ийн гүнтэй 44 шурф буюу 87 т/м, ”Жалга-2” талбайн дээд хэсэгт хайгуулын 10 шугамд 1.4-4.2м гүнтэй 59 шурф, доод хэсэгт хайгуулын 11 шугаманд 1.0-5.8м гүнтэй 78 шурф нийт 137 шурф буюу 393.2т/м, ”Шаазгайт дэнж” талбайд хайгуулын 7 шугамд 1.0-5.2м гүнтэй 69 шурф буюу 223т/м, ”Урд дэнж-1,2” талбайд хайгуулын 7 шугамд 0.6-5.8м гүнтэй 138 шурф буюу 387т/м, нийт хайгуулын ажлаар 388 шурф нэвтэрч 1090.2 т/м шурф нэвтрэлтийн ажил хийж гүйцэтгэсэн. Шурфын дундаж гүн 2.6-2.94м байсан. Сорьцлолтыг 0,2м-ийн ахицаар гүйцэтгэж нийт 4683 дээж авч ажилласан ба ордын нөөцийг “B+C” зэргээр тогтоосон байна. Гидрогеологийн цооногийн гүн нь 70.0 м, цооног дахь усны тогтонги түвшин 3.5 м, уст үеийн байрлал нь 3.5- 8.9 м, 45.0-60.0 м гүнд байрлана. Цооногийн ундарга 15.0 л/сек, түвшний бууралт 40.0 м болно. АХ-01\2021 дугаартай ашиглалтын худагт гүйцэтгэгч компани туршилт шавхалтын ажлыг хийж дуусгаад, цаашдын хэрэглээнд зориулан битүүмжлэн үлдээсэн байна. /Худалдаж авсан худгийн пасспортыг хавсаргав/

Худгийн координат	X	Y
1	101 18 24 33	45 48 27.53

Зураг 6. Худгийн байршил

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах юм. Битүү эргэлтийн системээр усыг ашиглахад хаягдлын болоод цэвэр усны санг байгуулна.

Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэнэ. Төслийн уурхайн хэмжээнд хуримтлагдах хөрсний ус болон одоогийн байгаа 1 худаг болон нэмж 3 худаг шинээр гаргаж хангахаар төлөвлөжээ.

1) Технологийн усан хангамж, усны хэрэглээ

Баяжуулах үйлдвэрт хэрэглэгдэх нийт усны хэрэгцээ нь элс баяжуулах үйлдвэрийн технологийн ба унд ахуйн хэрэгцээний зориулалтын уснаас бүрдэнэ. Технологийн усны гол хэрэглэгч нь угаан баяжуулах төхөөрөмж бөгөөд түүнийг угаалгын эхэнд нийт шаардагдах усаар 100% хангаж өгөх ба цаашид 75% эргэлтийн ус, үлдсэн 25% усаар нөхөгдөн тэжээгдэнэ. 2

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар

2 ТЭЗҮ 85 хуудас

эргүүлэн ашиглах юм. Битүү эргэлтийн системээр усыг ашиглахад хаягдлын болоод цэвэр усны санг байгуулна.

Үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах юм.

Ордын элс нь дунд зэргийн угаагдах шинж чанартай учир 1м3 элс угаахад 4.0м3 ус хэрэглэхээр тооцоолов. Тухайн орон нутгийн цаг агаарын байдлаас шалтгаалан усан сангийн усанд ууршилт шүүрэлтээс болж алдагдал гардаг. Иймд уг алдагдлыг гадаад эх үүсвэрээс цэвэр усаар нөхөж, худгийн түвшнийг тогтмол барьж байх шаардлагатай.

Хүснэгт 6. Угаан баяжуулах цехийн технологийн усны хэрэглээ

Ашиглалтын жил	Баяжуулах элс, мян.м3	Технологиийн ус, мян.м3	Шаардагдах цэвэр ус 25%, мян.м3
I-р жил	215.40	861.60	215.40
II-р жил	215.42	861.68	215.42
Нийт	430.82	1723.28	430.82

ТЭЗҮ-ээр 2 жилд олборлож дуусах бөгөөд нийт үйлдвэрлэлийн нөөцөөр 430.82 мян.м3 элс угаан баяжуулна. 1м3 элс баяжуулахад 4.0 м3 ус шаардлагатай гэж үзвэл нийт 2 жилд 1723.28 мян.м3 ус болж байгаа ба үүний 75 хувийг эргэлтээр 25 хувийг нэмэлтээр шаардлагатай гэж үзвэл 430.82 мян.м3 нэмэлтээр сэлбэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл уурхайн үүсмэл нуурыг 0.003 л/сек-ээр усыг сэлбэж байх шаардлагатай байх бөгөөд үүнд дээрх зайлуулах усны ундарга хангалттай байна.

2) Ундны болон ахуйн усан хангамж, усны хэрэглээ

Ахуйн хэрэглээний усны тооцоо: Уурхайд нийт 130 хүн ажиллана.

Нэг хүний ус хэрэглээний норм хоногт ажлын болоод ахуйн хэрэгцээнд дунджаар 80л орчим байна. Уурхайн ахуйн усыг худгаас зөөж хангана. (* - БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт –“Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр – 80л/хоног/хүн)

Хүснэгт 7. Ахуйн ундны усны тооцоо

№	Үзүүлэлтүүд	Норм,	Хүний тоо	Усны зарцуулалт

		л/хоног		м3/хоног	Жилд ажиллах хоног	мян.м3/жил
1	Ахуйн усны хэрэглээ	80	130	10.4	94	977.6

3) Зам талбайн усны хэрэглээ

БОАЖНХЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар батлсан ус хэрэглээний нормын 13-р хавсралтын дагуу 1 м2 гудамж, зам талбайг 2.0 л усаар усална гэсэн нормоор усны хэрэгцээг тодорхойлбол. Уурхайн дотоод тээврийн зам 12000 м2, хоногт 1 удаа услах ба жилд цэвэр ажиллах 94 хоног /1 жил дэхь ажиллах хоног/ усална гэж тооцлоо.

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4 цаг тутамд явуулна (зөвхөн өдрийн цагаар). Шаардлагатай тохиолдолд замд хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Тоос дарах ажлыг тоноглосон нэг усалгааны машин гүйцэтгэнэ. Эвдрэлд өртөх 1.2 га технологийн зам байна.

Хоногт хэрэглэх усны тооцоо:

12000 м2 · 2.0 л/хон · 1 удаа = 24 м3/хоног

Жилд хэрэглэх усны тооцоо:

24 м3 *30 хон = 720.0 м3/жил

Хүснэгт 8. Тоосжилт бууруулахад шаардагдах усны хэрэглээ

Ашиглалтын жил	Жилд услах зам, м2	1 м2 замын усалгаанд шаардагдах ус, литр	м3/хоног	м3/жил 30 хоног ажиллана
2025 он	12000.0	2.0	24.0	720.0
2025 он	12000.0	2.0	24.0	720.0
Нийт ашиглалтын 2 жилийн хугацаанд				1440.0

5) Нийт усны хэрэглээ

Хүснэгт 9. Усны нийт хэрэглээний тооцоо

№	Үзүүлэлтүүд	Усны зарцуулалт				Усны эх үүсвэр
		м3/жил		м3/хон	л/сек	
1	Зам талбайн усалгаа	1-р жил	720.0	24.0	-	Уурхайн шүүрлийн ус
2	Зам талбайн усалгаа	2-р жил	720.0	24.0	-	Уурхайн шүүрлийн ус
Нийт		1440.0		48.0		
3	Унд, ахуйн усны хэрэглээ	1-р жил	977.6	10.4	-	Өөрийн худгаас
4	Унд, ахуйн усны хэрэглээ	2-р жил	977.6	10.4	0.03	Өөрийн худгаас
Нийт		1,955.2		-	-	
Технологийн сэлбэх цэвэр усны тооцоо 25%[3]						
5	Баяжуулах усны хэрэглээ	1-р жил	215400.0	2,291.0	Шүүрлийн ус 3.3л/с Үйлдвэрлэлийн зориулалттай худаг 15 л/с,	25%-ийг өөрийн худаг болон шүүрлийн ус, голоос

3 ТЭЗҮ 85 хуудас

					голоос үлдсэн усыг сэлбэнэ	үлдсэн усыг сэлбэнэ
6	Баяжуулах усны хэрэглээ	2-р жил	215420.0	2,291.0	Шүүрлийн ус 3.3л/с Үйлдвэрлэлийн зориулалттай худаг 15 л/с, голоос үлдсэн усыг сэлбэнэ	25%-ийг өөрийн худаг болон шүүрлийн ус, голоос үлдсэн усыг сэлбэнэ
Нийт		430.82		-	-	
Шүүрлийн ус						
7	Шүүрлийн ус	жилд	-	285.12	3.3 л/с	Гидрогеолог и 11 хуудас

Нийт цэвэр усны хэрэглээ 2,325.4 мкуб байна.

Үйлдвэрлэлийн зориулалттай худаг 15 л/с буюу 1296 м3/хон болон шүүрлийн ус 285.12 м3/хон болон нэмэлт цаашид 3 худаг гаргах учраас усны ундарга хангалттай гэж үзлээ.

Зураг 7. Уурхайн кемпийн харагдах байдал

Зураг 8. Төслийн талбайн кемпийн ерөнхий төрх -№2 2023.07.24

Зураг 9. Төслийн талбайн цуглах цэг №3 2023.07.24

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Байгаль орчны төлөв байдал

Судалгааны талбай нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын төвөөс урагш 19 км, Баянхонгор аймгийн Өлзийт сумын төвөөс зүүн урагш 46 км-т оршино.

Газарзүйн онцлог: Судалгааны талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай Хэнтийн уулархаг их муж, Хангайн мужийн Хангайн өмнөд бэгэлцэгийн тойрогт хамаарагдана. (Зураг №3)

Хангайн нурууны тойрог нь Монгол орны төв хэсэгт байрлах, 500 км үргэлжлэх томоохон уулт тогтолцоо бөгөөд гол нуруу нь баруун хойноос зүүн ургаш чиглэн тогтох бол салбар уулс нь түүнээс өөр чиглэлтэй байдаг. Хангайн нурууны хамгийн өндөр оргил нь уг нурууны баруун урд хэсэгт байрлах Отгонтэнгэр уул (д.т.д 4021 м) юм. Гол нуруу нь хойш ургаш чиглэсэн голуудын хөндийгөөр зүсэгдэж хэсэгчлэгдсэн, орой хэсэгтээ хад асга, чулуу ихтэй, ар ташлан нь ой модтой, өвөр ташлан нь огцом хэвгий байдалтай юм.



Зураг № 3. Талбайн физик газарзүйн мужлалын зураг

Цаг уурын нөхцөл: Нутаг дэвсгэрийн уур амьсгал бүрэлдэн тогтоход нөлөөлөх хүчин зүйлсийн дотроос газарзүйнбайрлал ба газрын гадарга, нарнаас ирж буй цацраг илч, агаарын орчил хөдөлгөөн зэрэг бие биетэйгээ нягт холбоотой хүчин зүйл голчлон нөлөөлнө.

Судалгааны талбайн уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүдийг Өвөрхангай аймгийн Нарийнтээлсумын цаг уурын харуулын 2015-2020 оны мэдээг ашиглан боловсрууллаа.

Судалгааны талбай орчмын газар нутаг нь ерөнхийдөө дулаан уур амьсгалтай, хур чийг багатай. Өвлийн улиралд гэнэтийн дулааралт бараг ажиглагддаггүй бол зуны улиралд гэнэтийн хүйтрэлт хаяа тохиолдоно. Агаарын температурын бас нэг онцлог бол хавар, намрын улирал богинохон, халуун хүйтний солилцоо эрс байдаг явдал юм.

Нарийнтээл сумын нутаг өндөр уул нуруу багатай газрын гадаргын хэв шинж бараг нэг төрлийн учраас байгалийн ба уур амьсгалын нөхцөл нь онцын ялгаагүй уур амьсгалын голлох үзүүлэлт хур тунадас температур ургамлын ургалтын хугацааны чийгийн хангамжийн үзүүлэлтийг уур амьсгалынмужлалын гол үзүүлэлт болгон авч болно.

Нарийнтээл сумын нутаг дэвсгэр нь уур амьсгалын хувьд чийглэгдүү сэрүүвтэр мужид хамрагдана.

Сүүлийн 6 жилийн мэдээллээр жилд дунджаар 86.8-243.8 мм тунадас, дулааны улиралд 163.5мм, хүйтний улиралд 12.8 мм тунадас тус тус орох ба чийгийн хүрлцээ ерөнхийдөө сайн байдаг. 1-рсарын агаарын дундаж температур -12.6°C – -20.5 °C орчим хүйтэн, 7-р сарын агаарын дундаж температур 17.8°C – 21.6°C орчим дулаан байдаг ба жилийн хамгийн их дулаан байдаг 30.7°C, хамгийн бага нь -31.5°C хүрч хүйтэрч байсан байна.

Энэ нутаг дэвсгэрт дундаж температур хавар 4-р сарын сүүлийн арав хоногоос 10 градусыг дайрч дулаардаг бөгөөд намар 9-р сарын эхний арав хоногт 10 градус болж цаашид буурдаг. Анхны хүйтрэл 9 дүгээр сарын 12-20-ны хооронд, эцсийн хүйтрэл 4-р сарын 19-24-ний хооронд тохиолдоно.

Хөрсний шинж чанар: Судалгааны талбайн орчны нутаг дэвсгэр нь хөрс газар зүйн мужлалаар Хангай их мужын Өндрийн бүсшилтэй нутгийн Хангайн мужийн Хангайн өврийн 43-р тойрогтхамаарагдана. (Монгол орны үндэсний атлас 2009).



Зураг № 24. Монгол орны хөрс-газарзүйн мужлалын зураг

Судалгааны талбайн ихэнх хэсэг 3030.7 га буюу 93.8 хувьд нь Цайвар хүрэн хөрс багахан хэсэгт 200.3 га буюу 6.2 хувьд нь Аллювийн нугын хөрс тархсан байна. Эдгээр хөрсний тархалтын талаар товч дурьдахын зэрэгцээ хөрсний зургаар харууллаа.

Ургамал зүйн байдал: Судалгааны талбай нь Монгол орны ургамалжилтын бүс, бүслүүрээр **хээрийн болон цөлөрхөг хээрийн бүс**-т хамаарна.



Зураг № 42. Ургамалжилтын бүс бүслүүр

Хээрийн бүс: Хуурайсаг өвслөг ургамал зонхилсон нутгийг хээр гэдэг. Монголын хээр нь Мажар улсын дунайн “Пушти” хэмээх хээрээс Дорнод азийн манжуурын хээр хүртэл үргэлжлэх хээрийн дорнод хэсэг болно (Өлзийхутаг.Н, 1989). Хээрийн бүс нь Дорнод Монгол, Дундад Халхын

тэгш өндөрлөг, өргөн уудам тал газрыг хамарч, баруун тийш нарийсан нарийссаар Хангайн нурууны өврийн нам уулсын бэлээр дамжин Ханхөхийн өмнөд бэл хүртэл нарийн зурвас газраар Их нуруудын хотгорт хүрч замхарна (Өлзийхутаг.Н, 1989). Хээрийн бүс д.т.д 950 м-1724 м өндөрт оршино. Хээрийн бүсийн урд хэсгээр эрт үед усан сав газар нилээд их талбайг эзлэж байсныг гэрчлэх сул барьцалдан тогтсон хайрга, элстэй эртний нуруудын хурдас ихээр тархсан байна. Хамгийн нам хэсэгт нь үлдэц нуур тойром, хужир мараа, шал тойром бүхий хотгор газар бүхий тэгшивтэр гадаргатай. Тэдгээр нь хоорондоо жижиг цав толгодоор тусгаарлагдана. Хөдөө аж ахуйн уур амьсгалын мужлалаар хүйтэн өвлийн хэв шинжтэй, ургамлын чийг хангамжийн нөхцлөөр чийг багатай, хуурайвтар, хуурай дэд бүсэд хамаарагдаж байна (Үндэсний атлас, 2009). Ургамал газарзүйн мужлалаар Евроазийн хээрийн мужийн Дагуур Монголын хээрийн хошууны Дунд Халхын хээрийн тойрогт багтана.

Цөлөрхөг хээрийн бүс: Монголын цөлөрхөг хээр Говийн хойт хэсгийн зурвас газар Төв Азийн дотоодыг урсгалгүй ай савын хүрээнд дэлхийн усны хагалбараас өмнө тийш оршдог, зөвхөн энэ бүс нутагтаа ургадаг эдификаторуудаас бүрдсэн өвөрмөц ургамлуудтай байдаг бүс нутаг” (Юнатов.А.А, 1976) гэжээ. Их нуруудын хотгор, олон нуурын хөндий Говь-Алтайн нурууны хормой, Говийн олон нуурын хөндийд хамрагдана. Эвдрэлд хүчтэй өртсөн жижиг цав толгод гол төлөв өргөрөгийн чиглэлд сунаж тогтсон өргөн хөндий хоолойнуудтай ээлжлэн тааралдана. Хөндийн хоолойнуудын хамгийн нам хэсгүүдээр давстай жижиг нуурууд элбэг тохиолдоно. Дорноговийн цөлөрхөг хээрийн район зүүн урагш бага зэрэг хэвгий гадаргатай, д.т.д дээш 1200-1700 метрийн хооронд хэлбэлзэнэ.

Цөлөрхөг хээрт амьдралын хэлбэрийн хувьд хуурайсаг сөөгөнцрүүд нэлээд оролцож дэгнүүлт жижиг үетэн зонхилдгоороо онцлог юм. Уул тогодын бэл, уурс хоорондын өргөн хөндий, ухаа гүвээний бор хөрсөнд өдлөг хялганат (монгол өвст) цөлөрхөг хээр түгээмэл тааралддаг.

Хүснэгт № 2. Бэлчээрийн төрлийн ангилал

Индекс	Бэлчээрийн төрлийн ангиллын шифр	Бэлчээрийн төрлийн нэр	Талбайн хэмжээ, га
1	2	3	4
Төрөл: ЦХ-Цөлөрхөг хээрийн бэлчээр			
ЦХ-I		Анги: Гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн бабор хөрстэй цөлөрхөг хээр	
143	ЦХ-I-1-2	Монгол өвс-хазаар өвст	1884
Төрөл: Ө-Өндөр уулын бэлчээр			
Ө-III		Анги: Өндөр уулын нугат хээрийн болонбүдүүн ялзмагт хөрстэй хээр	1124
9	Ө-III-1-2	Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-бушилзат	
Төрөл: У-Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр			
У-VI		Анги: Уулын цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээр	
58	У-VI-1-1	Монгол өвс-ерхөгт	226

Төслийн талбай орчмын бүс нутагт хээрийн болон цөлөрхөг хээрийн ургамалжилт давамгайлах

бөгөөд Монгол өвс-хазаар өвст, Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, Монгол өвс-ерхөгт бүлгэмдлүүд тархсан байна.

Ургамлын бүрхэц нийт талбайн хэмжээнд дунджаар 40-50 хувийн бүрхэцтэй, дундаж өндөр олон наст үет ургамал 10-15 см, алаг өвс болон нэг наст ургамал 8-10 см өндөр ургасан байна.

Ан амьтан: Судалгааны талбай нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Олон нуурын хөндий мужид хамаарна.

Зураг № 47. Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлал



*Тайлбар: 1 - Хөвсгөлийн уулс, 2 - Хэнтий нуруу, 3 - Хангайн нуруу,4 - Монгол Дагуурын хээр, 5 - Их хянганы уулс, 6 - Монгол Алтайн нуруу, 7 - Төв халхын хээр**, 8** - Дорнод Монгол, 9 - Их нууруудын хотгор, **10 - Олон нуурын хөндий,** 11 - Умард говь, 12 - Дорнодговь, 13 - Говь Алтайн нуруу, 14 - Зүүнгарын говь цөл, 15 - Алтайн өвөр говь цөл, 16 - Алашань говь цөл*

Судалгааны талбайд тохиолдох амьтны аймгийн зүйлийн баялаг, амьдралын онцлогийг нутгийн иргэдийн аман мэдээ болон өөрсдийн судалгааны явцад цуглуулсан баримт, материал, ном хэвлэлийг ашиглан дараах байдлаар нэгтгэн дүгнэж байна.

Хөхтөн – Mammalia

Хээрийн хөхтөний бүлгэмдлийн бүлэгт хамаарах, ургамлын ногоон хэсгээр хооллодог, жилийн турш идэвхитэй, малтагч амьтдаас:

Үлийн цагаан оготно – Lasiopodmys Brandtii,

Дагуур огодой – Ochotona pallasii,

Орог зусар – Phodopus sungrus ,

Монгол чичүүл – Meriones unguiculatus, Сахалт багваахай – Myotis mystacinus, Монгол тарвага – Marmota sibirica,

Урт сүүлт зурам – Citellus undulates,

Хэргэлзэй оготно – Microtus gregalis,

Дагуур сохор номин – Myaspalax aspalax зэрэг хөхтөн тархжээ.

Махан идэшт агнуурын том амьтдаас: мануул – Felis manul, шилүүс – Felis lynx, нохой зээх – Gulo gulo, чоно – Canis lupus, үнэг – Vulpes vulpes, ирвэс – Panthera unica Schr;

Махан идэшт агнуурын жижиг амьтдаас: цагаан үен – Mustela ermina;

Ховор хөхтнөөс: дагуурын зараа – Erinaceus daurica, монгол оготно – Microtus mongolicus,

Шувуу – Abies

Энэ бүс нутгийн шувууны ангиас өндөглөж зусдаг ангир – Tadorna ferruginea, алаг шунгаач –Bucephala clagula, сохор элээ – Milvus migrans, оронгийн бор шувуу – Passer domesticus, хон хэрээ –Corvus corax (сээр нуруугүйтэн, шувуу, хөхтөн, хүүр сэгээр хооллоно) элбэг, суурин амьдралтай, ургамлаар хооллодог хөхвөр тагтаа – Columba livia, өндөглөж зусаж сээр нуруугүйтнээр хооллодог ханамал тагтаа – Cuculuc saturates, суурин амьдралтай хөхтнөөр хооллодог хувбэгбаатар – Strix uralensis, сээр нуруугүйтнээр хооллодог сахалт бөх бух – Panurus biarmicus хэвийн тархалттай байна. Харин өндөглөж зусдаг, хөхтнөөр хооллодог цармын бүргэд – Aquila chrysaetus, сээр нуруугүйтнээрхооллодог монгол хараацай – Hirunda daurica, хөвчийн хараацай – Ptonoprogne rupestris, монгол болжмор – Melancorypha mongolia, цэнхэр шаазгай – Cyanopica cyana зэргээс гадна ятуу, ногтруу, сар, тас зэрэг ховордож

буй шувууд, нэн ховордож буй шувуудаас алтайн хойлог – Tetraogallus altaicus, шонхор – falco vespertirus цөөн тоотой тархаж байна.

Хоёр нутагтан, мөлхөгчид – Amphida

Монгол бах (сэвсгэр шороонд булагдах ба байгалийн нүх хонгилд) – Bufo raddei, сибирь мэлхий (Сийрэг ой, усны ойролцоо байгалийн нүх хонгилд) – Rana amurensis, шивэр гүлмэр (усны ойролцоо,сийрэг ойн сэвсгэр шороонд булагдах ба байгалийн нүх хонгиол орогнодог) – Salamandrella keyserlingii, модны мэлхий (усны ойролцоо ургамал доор орогноно) – Hyla japonica хэвийн тархалттай тохиолдох бөгөөд эдгээр нь өдөр шөнийн холимог идэвхитэй бөгөөд сээр нуруугүй амьтнаар хооллодог. Харин усны могой (усны ойролцоо, сийрэг ой, байгалийн нүх хонгилд бусад амьтны нүхэнд орогноно) – Natrix natrix нь ховор тохиолдох ба өдрийн идэвхитэй, жижиг сээр нуруутан банууругүй амьтнаар хооллоно.

Шавьж

Хамгийн олон янзын шавьжтай. Хатуувтар далавчтан (Hemiptera), хатуу далавчтан (Coleoptera), хайрсан далавчтан (Lepidoptera), зөөлөн биет цох (Cantharidae), шүрэн цох (Coccinellidae), мана бясаа (Miridae), шулуун далавчтан (Orthoptera), хар цох (Tenebrionidae), шөвгөр цох (Curculionidae) зонхилно.

Бут сөөг, өвсөнд амьдрагч шавьж нэн элбэг. Нийт шавьжийн тоо маш олон, тархалт нь жигд биш байна. Зуны эхэн үед шавьж олширно. Хөрсний шавьж ихтэй.

2.2 Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Судалгааны талбай нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Баянхонгор аймгийн Өлзийт сумдын нутаг дэвсгэрийг дамнан байрладаг тул тус сумдуудын нийгэм эдийн засгийн товч мэдээллийг авч үзлээ. Төслийн БОННҮ-ий явцад төсөл хэрэгжих сум, багийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж дүгнэлт гаргах шаардлагатай.

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сум

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сум нь 1931 онд байгуулагдсан. Шарга, Баянтээг, Өндөрхөмөг, Цагаан-овоо гэсэн 4 багийн нийт 1008 өрхөд 3653 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Өвөрхангай аймгийн 19 сумаас эхнээсээ 10-д, газар нутгийн хэмжээгээр 9-д ордог. Нийт газар нутгийн хэмжээ 270170 га.

Зураг № 48. Нарийнтээл сумын төв

Өвөрхангай аймгийн Хужирт, Уянга, Архангай аймгийн Цэнхэр, Хотонт, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумтай хиллэдэг. Тус сумын хүн амын 37 хувь нь сумын төвд, 63 хувь нь хөдөөд амьдардаг. Сумын хүн амын 56.6 хувь нь залуу болон дунд насныхан, 36.8 хувь нь хүүхэд, 6.6 хувь нь ахмадууд байна.

Сумын хэмжээгээр нийт 135968 мал тоологдсоноос цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 151 толгой мал тоологдсон нь нийт малын 0.1 хувь байна. Үүнээс: Адуу – 11948, үхэр – 17061, хонь – 52357, ямаа – 54632 толгой малтай. Малчин болон, мал бүхий өрх 1182 байгаа нь сумын нийт өрхийн 56.6 хувийг эзэлж байна. Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг 1, Баянтээг багийн төвд гүний худаг 1 ажиллаж байна.

Сумын газар нутаг дээгүүр Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор аймгуудыг нийслэлтэй холбосон улсын чанартай хот хоорондын авто зам дайран өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогддог. Сумын хэмжээнд нийт 37 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Улсын үйлдвэрийн газар Баянтээгийн нүүрсний уурхай байнга ажилладаг. Хөх нуруунд өөхөн цагаан чулууны орд газартай. 2 дугаар багийн нутаг Шинжитийн хоолой, Таацын гол дагуу алтны ордтой. Таацын халуун рашаан, Шаргын тасархай, Ламын гэгээний суварга, Цэвэлваанчигдоржийн суварга, Ноён хатан цохио зэрэг түүх соёлын дургалт газруудтай.

Судалгааны талбай нь тус сумын 2-р багийн (Баянтээг) нутагт дэвсгэрт харьяалагдаж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай түүний ойролцоо (5.0 км) Нарийнтээл сумын малчин иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий 16 хаваржаа (Өвөлжөө) оршиж байна. (Зураг 49)

Баянхонгор аймгийн Өлзийт сум

Баянхонгор аймгийн Өлзийт сум нь 1924 онд байгуулагдсан. Бурхант, Байн-Ам, Ёлын-Ам,

Худаг-Урт, Бийрийн Уулзвар, Улаан-Уул гэсэн 6 багийн нийт 1021 өрхөд 3590 хүн амьдардаг. Хүн амын тоогоор аймагтаа эхний 3-т, газар нутгийн хэмжээгээрээ дээгүүр орох бөгөөд, хүн амын нягтралаар дундаж буюу 3.8 хүнтэй сум юм. Нийт газар нутгийн хэмжээ 385283 га. Нутгийн зүүн хэсгээрээ Өвөрхангай аймгийн Уянга, Нарийн тээл сумдтай, урд хэсгээрээ өөрийн аймгийн Богд, Жинст, баруун хэсгээрээ Баян-Овоо, хойд хэсгээрээ Эрдэнэцогт сумдтай тус тус хиллэдэг.

Сумын хэмжээнд мал сүргийн тоо 207692, үүнээс тэмээ 378, адуу 10380, үхэр 9295, хонь 58949, ямаа 128690 толгой байна. Нийт өрхөөс малтай өрхийн тоо 875, үүнээс малчин өрхийн тоо 791, малчдын тоо 1553 байдаг нь нийт өрхийн 77.5 хувийг эзэлж байна.

Дэд бүтэц сайн хөгжсөн, эрчим хүч, цахилгааны хангамж сайтай. Төвлөрсөн халаалтын системтэй.

Сумын газар нутаг дээгүүр Баянхонгор аймгийг нийслэлтэй холбосон улсын чанартай 50 км авто зам дайран өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогддог.

Тус сумын хэмжээнд төсвийн 6 байгууллага, 17 хоршоо, Хөх бүрдний эх”, “Их богд” ХХК, Хаш гоёо” ХХК зэрэг нийт 23 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн ойролцоо (5.0 км) Өлзийт сумын малчин иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий 7 хаваржаа (Өвөлжөө) оршиж байна. (Зураг 50)

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 10. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа

Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Сөрөг Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
Нэг. Төслийн үйл ажиллагааны явцад				
Шатах тослох материал, ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Гүний ус, ургамал	Төслийн талбай	Бага	Төсөл хэрэгжих хугацаанд
Зам, жим харгуй ихсэх	Агаар, хөрс, амьтан,	Авто зам түүний ойр орчим	Дунд	Төсөл хэрэгжих хугацаанд
Олборлолтонд өртөх	Газрын хэвлий	Төслийн талбай	Дунд	Төсөл хэрэгжих хугацаанд

Хүснэгт 11. Гол нөлөөллийн дүн шинжилгээ

Нөлөөллийн ангилал	Гол нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ	Нөлөөллийн эрчим	Нөлөөллийн үргэлжлэх хугацаа
1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Эвдэх	• Санамсаргүй алдаа гарсан тохиодолд автомашины тос алдаж хөрс, шороо бохирддог. • Хөрс эвдэх нөлөөлөлд уурхайн хөрсийг дурааараа сэндийчих, барилга өргөтгөн барих ажлууд хамаарагдаж байна.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ	Хөрс бохирдуулах нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна. Хөрс эвдэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд

• Доройтуулах	• Доройтуулах нөлөөлөлд автомашины хүн тээврийн маршрут, хог хаягдлын төвлөрсөн цэгийг хашаалаагүй зэрэг хамаарагдаж байна.		Хөрс доройтуулах нөлөөллийн эрчим дунд зэрэг эрчимтэй байна.	
2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Нөөцийг бууруулах	Үйл ажиллагааны явцад гүний усыг бохирдуулах нөлөөлөл нь ШТМ асгарах зэрэг орно. Газрын гүний ус ашигладаг учраас нөөцөд бага зэрэг нөлөөлнө.		Газрын гүний усны нөөцийг бууруулах нөлөөллийн эрчим их байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл • Амьдрах орчинг хуваах • Амьдрах орчинг доройтуулах • Амьдрах орчинг хомсдуулах • Нөөцийг бууруулах	Хүнд даацын хөдөлгөөн нь тэдгээрийн амьдрах орчныг хуваах, доройтуулах, хомсдуулах нөлөөллийг үзүүлж байна.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ	Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
4. Агаарт үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Тоос	Галлагааны зуухаас угаар, автомашины шатаасан хийн угаар нь агаарыг бохирдуулж түүний чанарыг доройтуулдаг. Замын барилгын ажил нь агаарт тоос дэгдээж сөрөг нөлөө үзүүлдэг.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд зэргийн эрчимтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд

5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс • Хамгаалах Нүүлгэн шилжүүлэх	-	-	-	-

Эндээс үзэхэд тус төслийн эдэлбэр газар төдийгүй орчны газар нутгийг хамгаалалтад авч, авто хөсгийг зөвхөн тогтоосон замаар явуулж, үйлчлүүлэгчдийн тоог тогтоосон норм хэмжээнээс давуулахгүй байхыг үл харгалзваас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамал нөмрөгийг алдралд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдож, ургацын хэмжээ буурч, экологийн тэнцвэрт байдал алдагдахад дөхөм үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь хүнд даацын автомашины хөл хөдөлгөөн ихсэх, төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр холхиж олон салаа зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах нь хөрс, усны бохирдол, ургамлан нөмрөг алдралд орон хомсдож биомассын хэмжээ багасах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах бүлэгт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

3.1 Төслийн гадаад болон дотоод овоолго барьж байгуулах үеийн гол нөлөөлөл

- Гадаад болон дотоод овоолгыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах явцад хөрс, ургамал механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах
- Будаг, маажин, цавуу мэтийн химийн бодис асгарснаас хөрс ургамал, хөрсний ус, голын ус бохирдох, амьд организм хордох
- Нунтаг болон цементийн зуурмаг, шохой асгаж, модны зомгол, золтос, үйрдэс, шилний хагархай зэрэг элдэв төрлийн хог хаягдлаар орчныг бохирдуулах
- Төслийн талбайн хөрс, ургамал бүхэлдээ эвдрэл, элэгдэлд орно.

3.2 Гадаад болон дотоод овоолго байгуулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл

- Объектын орчин тойронд хөрс, ургамлан нөмрөг элэгдэл, эвдрэлд орох
- Зам жим, барилга байгууламжийн орчны хөрс талхлагдах, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, үйлчлүүлэгчдийн тоо олширсноор голын эрэг бохирдох
- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох зэргээр илэрнэ.

Төслийн байгууламжийг барих эхний үе шатанд объектыг байгуулах, газар шорооны ажил гүйцэтгэхэд тухайн орчны хөрс, ургамал нэн түрүүнд өртөж, суваг шуудуу татах зэрэгт рельефийн зарим хэлбэрийн үндсэн төрх алдагдах, шинээр бичил хэлбэр бий болж, газрын хөрсний механик бүтэц, ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Ийм тохиолдолд тухайн байгууламж барих хэсгийн өнгөн хөрсийг хуулж овоолго хийж нөхөн сэргээлт болон цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах нь зүйтэй. Нөхөн сэргээхдээ төсөлд тусгасан зураг төслийн дагуу тухайн орчинд зохицсон ургамал тарих шаардлагатай.

Овоолго барих үеийн нөлөөллийн төрөл нэлээд олон байгаа хэдий ч хамрах хүрээ нь бага, эрчим нь их байна. Иймд байгууламжийг барьж дууссаны дараа нөхөн сэргээх ажлыг яаралтай хийх шаардлагатай. Ашиглалт жигдэрсний дараа орчинд үзүүлэх нөлөөллүүд нь түүний олон талт үйл ажиллагаатай уялдан хүрээгээ тэлэх магадлалтай байгаа нь ажиглагдаж байна.

Тус төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бүхий л хүрээнд авч үзвэл: хөрс дагтарших, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, голын ус болон эрэг бохирдох, хөрсний усаар дамжин гүний ус бохирдох, биомассын хэмжээ багасах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн, хорхой шавьж хордож устах, мөлхөгч, мэрэгчид, жигүүртэн шувууд дайжих, мод бут өвс ургамал механик гэмтэлд өртөх гэж үзэв.

Эдгээр сөрөг нөлөөлөл нь нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан асуудлуудад хайхрамжгүй хандсанаас үүсч болно. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг дараах бүлэгт дэлгэрэнгүй оруулсан бөгөөд тус зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч цаашид мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих орчимд агаарын бохирдол харьцангуй бага байна гэж үзэж байна. Энэ нутгийн агаар, ус, хөрс, ургамал байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан бөгөөд ялангуяа уг төсөл хэрэгжих талбай нь хүний суурьшилын бүсээс зайтай, тухайн орчимд агаар орчинд хүчтэй нөлөөлж бохирдуулах эх үүсвэр байхгүй учир тухайн төсөл хэрэгжих талбайн агаар нь харьцангуй цэвэр ба төслийн үйл ажиллагаанаас суурьшлын бүсэд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байна.

Төсөл хэрэгжих орчмын агаарын бохирдлын эх үүсвэр нь барилга байгууламж барих явцад үүсэх тоосжилт, барилгажилтанд ажиллах машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ зэрэг болно.

Мөн агаарын бохирдлын гол үүсвэрийн нэг нь байгалийн хүчин зүйл болох шороон шуурга гэж болно. Чухам ийм үед л тоос, шороо ихээр дэгдэж агаар орчныг бохирдуулна.

Цаашид уурхайн тээврийн хэрэгслийн ирж очих машин механизмуудын түлшний шаталтаас үүсэх хорт хий, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын чанарт хими болон физикийн тодорхой нөлөөллийг бага хэмжээгээр үзүүлэх болно.

Дээрх нөлөөллийн хэлбэрийг доор дурдсан байдлаар ялган төсөөлж болох юм. Үүнд:

- Ургамалын бүрхүүл, бэлчээр тоос шороонд дарагдах
- Агаар дахь тоосны агууламж ихсэн хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлөх

Иймд төсөл хэрэгжих орчин нь уул уурхайн бүс гэдгийг харгалзан үзэж хүний үйл ажилагаанаас үүдэлтэй тоосны сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам, хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох нь нэн чухал юм.

Тээвэрлэлтийн /уурхайн олборлолтын/ үед эвдэрсэн газрыг тухай бүр нөхөн сэргээх, аль болохоор олон салаа зам гаргахгүй байх, автомашин зорчих гол замыг цаашдаа хатуу хучилттай болгох зэрэг бололцоотой бүхий л арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

Хийн хаягдлаас үүсэх гол сөрөг нөлөөлөл

Автомашины утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310г, дизель хөдөлгүүр 80-100г хорт бодис ялгаруулна. 1кг шатахууныг литрт шилжүүлэн (бензин q=0.725, дизель q=0.825) бодож, түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашины утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлохдоо бензин хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба азотын ислийн агууламжийг, дизель хөдөлгүүрт бол хөө тортогийн агууламжийг үндсэн үзүүлэлт болгодог.

Хүснэгт 12. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ

Бохирдол	**Автомашин асаалттай, сул зогсолттой байх үед**	**Машин хурдтай явж байх үед (60 км/цагаас дээш)**	**Машин тойргоор эргэх үед**	**Машины хурд саарч байх үед (60 км/цагаас доош)**
CO (%)	4 – 9	< 1 – 8	1 – 7	2 – 9
HC, C_6H_{14} (ppm)	500 – 1000	50 – 80	200 – 800	3000 – 12 000
NO_x (ppm)	10 – 50	1000 - 4000	1000- 3000	5 – 50

Дээрх хоёр төрлийн хөдөлгүүрийн утааны дундаж найрлагыг дараах хүснэгтэд харуулав. Энэ нь байгаль орчинд цацагдаж байгаа утааны техникийн болон мониторингийн хяналтын үзүүлэлт, ашиглагдах ач холбогдол юм.

Хүснэгт 13. Автомашины утааны бүрдэл найрлага

№	**Бүрдэл**	**Хөдөлгүүрийн төрөл**		**Тайлбар**
		Бензин	Дизель	
1	Азот (%)	74-77	76-78	**Хоргүй**
2	Хүчилтөрөгч %)	0.3-8	2-18	**Хоргүй**
3	Усны уур (%)	3-5.5	0.5-4	**Хоргүй**
4	Нүүрсхүчлийн хий (%)	5-12	1-10	**Хоргүй**
5	Нүүрстөрөгчийн исэл (%)	1-10	0.01-0.5	**Хортой**
6	Азотын исэл (%)	0.1-0.5	0.001-0.4	**Хортой**
7	Альдегид (%)	0.0-0.2	0-0.009	**Хортой**
8	Нүүрс-устөрөгчид (%)	0.01-0.02	0.01-0.5	**Хортой**
9	Хүхэрлэг хий (%)	0-0.002	0-0.03	**Хортой**
10	Хөө тортог (г/$м^3$)	0-0.44	0.01-1.1	**Хортой**
11	Бенз (а) пирен (г/$м^3$)	<0.00002	<0.00001	Хортой

Хүснэгтээс харахад, 1л бензин шатаахад ялгарах хорт бодисын хэмжээ нь дизель түлшнийхээс дунджаар 3.1 дахин их байгаа бөгөөд зөрүүгийн хэмжээ нь 3-4 хооронд хэлбэлзэж байдгийг судалгаагаар тогтоосон байна.

3.4 Төлөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Уг төсөл хэрэгжих талбай нь байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөө, мөн хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газрын гадарга болон хэвлийн их хэмжээний эвдрэлтэй, ихэнх хэсэг харьцангуй унаган төрхөө хадгалсан, хэсэг газар ургамал хөрс талхлагдаж, ухмал нүх үүссэн, одоогийн байдлаар бага зэрэг хог хаягдалтай байна.

Тус төсөл хэрэгжихэд нийт талбайн 31% буюу 15.0 га талбайн гадаргуу өртөгдөж байгаль орчинд сөрөг нөлөө учруулна.

- **Төслийн олборлолтын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Газрын хэвлий ухах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс үүдэн хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, үүний улмаас элсэнцэр хөрс салхинд хийсэх, элсжилт үүсэх
- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр газрын гадарга, хэвлий бохирдох
- Болзошгүй тохиолдлоор гал алдах, түймэр гарах

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх шаардлагатай.

3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газар нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс-био уур амьсгалын Хангайн мужийн өндрийн бүсшил бүхий Хангай-Хэнтийн өмнөдийн хэв шинж бүхий 52 дугаар тойрогт хамрагдана. Энд уулын бэлээр нугын, уулын хойд хажуугаар уулын ширэгт-тайгын, уулын хар шороон, уулын ойн бараан, уулын хар шороон, уулын хар хүрэн хөрснүүд тус тус тархана.

Төслийн үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй нөлөөллүүдийг жагсаан үзүүлбэл:

Төслийн кемпийн барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Байгууламжийн материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, төсөл хэрэгжих явцад хөрс, ургамал, мод бут механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах гэх мэт орно.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, хөрс суларч цас бороony усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.

3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Уурхайн олборлолт болон төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр /тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг/ зүйлийн бүрдлийн хэвийн байдалд өөрчлөлт гарч, орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр

талхлагдаж, тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төсөл орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдах,
- Тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно. /Хогийн ургамал/
- Төсөл орчмын мод бут механик гэмтэлд өртөх

3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбай орчмын нутаг нь монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар Олон нуурынхөндий мужид багтана.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр бичил биетэн устах, хордох
- Төслийн олборлолтын ажлын үеийн тэсрэлт болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл

Гадаргын болон гүний усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдэд, бичил бохир цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн усыг тоосжилт болон ногоон байгууламжийн усалгаа зэрэгт эргүүлэн ашиглах, үер болохоос сэргийлж далан байгуулах, голын ойр орчимд ахуйн болон үйлдвэрийн бохирдлоос сэргийлэх хамгаалалтын төлөвлөгөө, анхааруулга сэрэмжлүүлэг бүхий самбар, мөн гүний ус ашиглалтыг хянах, хэрэглээг багасгах, гүний усны цооног болон гүний худгийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг багтана.

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсний ус болон борооны усаар дамжуулан гол горхи бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын гол горхины ус ба түүний эргийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Голын усны горим хүний үйл ажиллагааны нөлөөгөөр урсацын горимын үйл ажиллагаа алдагдах

3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Уул уурхайн үйл ажиллагаа нь улс орон нутгийн төсөвт багагүй орлого оруулах, зуны улиралд ажлын цөөнгүй байр гардаг нь ажилгүйдлийг багасгах, хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх чухал хүчин зүйл болж байна. Тухайн орон нутгийн

экологийн чадавхаас хэтэрсэн ажил үйлчилгээ эрхлэх хэт олон том жижиг уурхай байгуулж хүн амын төвлөрөл бий болгох хөл хөдөлгөөн ихэсгэхээс аль болохоор зайлсхийх, бүс нутгийн дүрэм журмын дагуу зохих хязгаарлалт хийх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд нэгэнт байгуулагдсан болон байгуулах гэж буй уурхай нь байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамгийн бага хэмжээнд хүртэл нь бууруулах талаар туйлын хариуцлагатай хандаж идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь чухал юм.

Төслийн олборлолтын ажлын тоос болон дуу чимээний нөлөө нь ойролцоо оршин суугч иргэдэд нөлөөлөл үзүүлэх болно. Оршин суугч иргэдийн ашигладаг худгийн ойролцоо гүний усыг ашигласнаар бага гүний усны түвшин буурч энэ нь ойролцоох өрхүүдэд шууд нөлөөлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

3.11 Хуримтлагдах нөлөөлөл

“Мөрөн майнинг” ХХК-ийн алтны шороон орд төсөл нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сум болон Баянхонгор аймгийн Өлзийт сумд дамнан тухайн бүс нутагт уул уурхайн орд газруудын үйл ажиллагаа явагддаг ба төслүүдийн зүгээс хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засагт эерэг болон сөрөг нөлөөг тодорхой хэмжээгээр үзүүлэх юм. Үүнээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь энэ төслийн сөрөг нөлөөтэй уялдан газар ашиглалт, хөрсний бохирдол, хөрсний талхагдал, агаарын чанар, ан амьтны дайжилт, ургамлан нөмрөг доройтох зэргээр хуримтлагдах нөлөөллийг үзүүлнэ. Иймд эдгээр хуримтлагдах нөлөөллөөс өөрийн нөлөөллийн байдлыг ялган салгахын тулд нөлөөллийн бүсэд тогтоосон БОМТ-г цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, тайлагнах нь зүйтэй.

Төсөл хэрэгжих явцад уурхайн олборлолт, төслийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа болон орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй, богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэж болзошгүй.

Хүснэгт 14. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл

№	Хуримтлагдах нөлөөлөл	Нөлөөллийн шалтгаан	Хамрах цар хүрээ	Үргэлжлэх хугацаа
1	Газрын гадарга ба хэвлий эвдрэлд өртөх	Бусад төслүүдийн нөлөөлөл	Төслийн талбай, нөлөөллийн бүс	Өнгөрсөн, одоо, ирээдүй
2	Газрын доорх усны нөөц багасах	Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхцал		Одоо, ирээдүй
3	Гадаргын ус бохирдох	Бусад төслүүдийн нөлөөлөл		Өнгөрсөн, одоо, ирээдүй
4	Ургамлан нөмрөгийн доройтол	Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа		Өнгөрсөн, одоо, ирээдүй
5	Агаарын бохирдол нэмэгдэх	Хуурайшилт, бусад төслүүдийн бохирдол		Өнгөрсөн, одоо, ирээдүй
6	Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй

7	Амьтан дайжих, тоо толгой цөөрөх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй

Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шат хэрэгжсэний дараа төслийн үйл ажиллагаанд мониторинг хийхийг зөвлөж байна.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Зардлын утга	Нийт зардал, төгрөг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	1,800,000
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	3,500,000
3	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлын зардал	1,800,000
4	Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	3,000,000
5	Нөхөн сэргээлтийн ажлын зардал /*техникийн нөхөн сэргээлтийн ажил* /	12,000,000
6	6.Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10,000,000
7	7.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, нийгмийн хариуцлагын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	73,600,000
8	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	4,800,000
9	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	1,132,000
10	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	2,400,000
11	Төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах зардал	1,000,000
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	3,600,000
	Нийт дүн	**118,632,000**

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ

“Мөрөн майнинг” ХХК нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул эрсдэлийг гаргахгүй байх тал дээр зорилт тавин ажиллаж байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Биелэлтийн үр дүн
	1	2	
1	Дүйцүүлэн хамгаалах ажилд биотехникийн арга хэмжээ хийх	2000.0	Үзүүр хүрэн ууланд өвс тарааж тавьж өгсөн.
2	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	-	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан, 2025 оны биелэлтийн тайланг дүгнүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. Хавсралтаар оруулав.

	болон биелэлт батлуулах		
3.	Хогны гэрээ байгуулах	1019.0	2025 онд хогны гэрээ байгуулсан хавсралтаар оруулав. Хогны төлбөр төлсөн баримт хавсаргав. БАТЛАВ. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.СУГАР 2024 оны 01 сарын 01-ны өдөр ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ 2024 оны 01 сарын 05 өдөр № Цагаан-Овоо **НЭГ. Нийтлэг үндэслэл** Монгол улсын байгаль хамгаалах тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн 17-р дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйлүүдийг үндэслэв. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллах амьдрах орчыг бий болгоход оршино. **Хоёр. Гэрээ байгуулагч талууд** Нэг талаас Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын ЗДТГ-ыг төлөөлж ЗДТГ-ын дарга Б.Сугар нөгөө талаас “Импэро майнинг” ХХК-ний гүйцэтгэх захирал Б.Батцэцэг нар харилцан тохиролцож 2024 оны 01-р сарын 01-ны өдрөөс 2024 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав. **Гурав. Төлбөр тооцсон байдал** 30 хүнтэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд бэлтгэл ажил гүйцэтгэлийн хугацааг дуустал төлбөрийг тооцов. Ажиллах хугацаа:05 сар Жилийн төлбөр: 1.019.897төгрөг **Дөрөв. Сумын ЗДТГ-ын эрх үүрэг** ○ Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах ○ Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих. ○ Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах **Тав. Аж ахуй нэгжийн эрх үүрэг**

	Нийт	14819.0	

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Мөрөн майнинг” ХХК нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ.

Хүснэгт 15. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн нотолгоо

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	**Байгалийн бүрдэл хэсэг**	**Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**	**Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ**	**Хэрэгжүүлэх цар хүрээ**	**Биелэлтийн үр дүн**
Үйл ажиллагааны үе шаганд	Агаарын чанар	• Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох	• Зам талбай, овоолго, тоос босох гадаргууг усалгаа хийж тоосжилт бууруулах арга хэмжээ авах	Уурхайн талбайд	

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	**Байгалийн бүрдэл хэсэг**	**Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**	**Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ**	**Хэрэгжүүлэх цар хүрээ**	**Биелэлтийн үр дүн**
	Гүний ус	• Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх	• Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах https://hsct.mn/	Төслийн хүрээнд	

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	**Байгалийн бүрдэл хэсэг**	**Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**	**Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ**	**Хэрэгжүүлэх цар хүрээ**	**Биелэлтийн үр дүн**
	Хөрсөн бүрхэвч	• Техникийн нөхөн сэргээлтийг арга зүйн дагуу хийгээгүй тохиолдолд хөрсөн бүрхэвч доройтох, нөхөн сэргэх чадвараа алдах	• Төслийн автозогсоол, орц гарц болон уурхай талбай бүхий тэмдэглэгээ байршуулах, сэргээх	Уурхайн талбайд	
	Ургамалан нөмрөг	• Уурхайн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвч доройтох	• Нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэх	Уурхайн талбайд	2025 онд нийт 15,05га талбайд олборлолтын ажил явуулсан. - 12,26га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж 0,2м хөрс хучилт хийгдсэн - 2,79 га талбайд 2026 онд угаах төхөөрөмж нүүлгэхтэй холбоотой төхөөрөмжийн тэжээлийн цэврийн нуур болгохоор бэлтгээд байна.

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	**Байгалийн бүрдэл хэсэг**	**Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**	**Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ**	**Хэрэгжүүлэх цар хүрээ**	**Биелэлтийн үр дүн**
					Биологийн нөхөн сэргээлт жалга-1 хэсэгт 7,08га хийгдэж - кемп ард талд жалга-2 дээд хэсэгт 0,1га талбайд мод тарьсан
	Амьтны аймаг	• Уурхайн ажилчид хууль бусаар амьтан агнах үйлдэл гаргах	• Ажилчдад амьтны тухай хууль, байгаль хамгаалах талаар сургалт хийж байх	Уурхайн талбай, бутлах үйлдвэрийн орчимд	Ажилчдад амьтны тухай хууль, байгаль хамгаалах талаар сургалт сар бүр хийдэг.

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	**Байгалийн бүрдэл хэсэг**	**Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**	**Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ**	**Хэрэгжүүлэх цар хүрээ**	**Биелэлтийн үр дүн**	
		• ЦДАШ-ыг шувуу мөргөх, тогонд цохиулах	Шувууны шувууны суулт 2 ширхэг /үүр/ суурилуулах	Уурхайн ухашаас гадагшаа		
Нийт						**1100.0 (Нэг сая нэг зуун мянган төгрөг)**

ЗУРГАА.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая төг	Биелэлтийн үр дүн		
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт- гадаад овоолго --Өөрийн техниктэй	-	га	-		2025 онд нийт 15.05га талбайд олборлолтын ажил явуулсан. - 12.26га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж 0,2м хөрс хучилт хийгдсэн. - 2,79 га талбайд 2026 онд угаах төхөөрөмж нүүлгэхтэй холбоотой төхөөрөмжийн тэжээлийн цэврийн нуур болгохоор бэлтгээд байна.		
2.	Техникийн нөхөн сэргээлт- дотоод овоолго --Өөрийн техниктэй	6,0 га бүхий дотоод овоолго хийнэ.	га	6.0		Техникийн нөхөн сэргээлтүүд хийгдсэн. 12,26га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж 0,2м хөрс хучилт хийгдсэн 		

3.	Тэрбум мод тарих	Төслийн талбайд салхин доод талдаа модоор хашлага хийх *(Тайлбар: “Улаанбаатар хотын 2014 онд тарилтад тэнцэх мод сөөгийн тарьц, суулгацын ААНБ-ын судалгаа” “Тоонот байгаль” ТББ-ын үнийн дүнгээр авав.)*	ширхэг	50	2000.0	Аймгийн хэмжээнд 7 га газар 60000 мод тарих ажлын хүрээнд хашаа барих 25 сая төгрөгийг орон нутагт өгсөн. Төлбөрийн баримтыг хавсаргав.
4.	Биологийн нөхөн сэргээлт-шимт хөрс болон биологи	Эвдэрсэн газар бүхий 7.08 га талбайг шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийнэ.	га	7.08	25000.0	• Биологийн нөхөн сэргээлт жалга-1 хэсэгт 7,08га хийгдэж - кемп ард талд жалга-2 дээд хэсэгт 0,1га талбайд мод тарьсан

2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн 12.26 га талбайн байршлын зураглал



ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Биелэлтийн үр дүн		
	1	2	3	4	5	6	7	8
1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн	Мод тарих байршлыг орон нутагтай тохиролцоно	-	50ш	2000.0	Аймгийн хэмжээнд 7 га газар 60000 мод тарих ажлын хүрээнд хашаа барих 25 сая төгрөгийг орон нутагт өгсөн. Төлбөрийн баримтыг хавсаргав.		

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн ашиглалтын нөлөөллийн бүсэд малчдын хаваржаа болон зуслан, намаржаа байхгүй.

ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

АРАВ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5	6
1.	Ажилчид болон үйлчлүүлэгчийн бие өвдөх, халдварт өвчин гарах	Ажилчдын эрүүл мэндийн үзлэг	Нийт ажилчид	33	100.0	Жил бүрийн ажилтнуудын эрт илрүүлэг бүхий эрүүл мэндийн үзлэгийг хийлгэсэн.
2.	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр уурхайн кемпийг бүрэн хангах	Нийт ажилчид	33	10.0	
	Нийт					**330.0**

АРВАН НЭГ.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Биелэлтийн үр дүн
	1	2	3	4	5	6	7
1.	Ахуйн	Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж хаях, хогийн гэрээг сунгуулах, хогны төлбөр төлөх	Түр хадгалах хог хаягдлын цэг	-	100.0	3	

2.	Аюултай	Аюултай хог хаягдал аккумлятор, ашигласан тос маслыг цуглуулах, гэрээт компанид нийлүүлэх	Түр хадгалах хог хаягдлын цэг	-	-	-			
	Нийт						300.0		

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэрээр нь барилгын болон ажилчдын буюу ахуйн гэж хоёр ангилна. Шинж чанараар нь хатуу, шингэн, хий гэж хувааж болно.

Төслийг хэрэгжүүлэх явцад барилгын ажилчдын түр суурин байгуулах ба үүсэн гарах ахуйн хог хаягдлыг дараах журмаар зохицуулна. Ялгаатай гурван өнгийн хог ангилан цуглуулах савыг барилгын ажилчдын түр сууринд байрлуулна. Доорх хүснэгт үзүүлсэн хаяг болон зааврыг сав бүрд байрлуулна. Эдгээр саванд хогийг зааврын дагуу ангилан хийж байгаа эсэхэд тухайн төслийн байгаль орчин эсвэл эрүүл ахуйн мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.

	Өнгийн шил, гэрлийн шил, толь, цонхны болон бусад шил хийхийг хориглоно!!!!
	Цаас болон бусад сонин сэтгүүл, цаасан хайрцаг, уут гэх мэт цаасан бүтээгдэхүүн, ус үл нэвтрүүлэх хайрцгууд. Эдгээрийг хогийн саванд хийхийн өмнө хавтгайлж нугалж хийнэ!!!
	Төмөр, хуванцар сав, баглаа боодол болон хуванцар сав хийнэ. Резин болон гялгар эдийг хийхгүй!!!

Зураг 10. Хогийн савны төрөл

Хогийн саванд тавигдах шаардлага: (Хог хаягдлын тухай хууль)

15.1.1.хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

15.1.2.галд тэсвэртэй материалаар хийгдсэн;

15.1.3.хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

Хог хаягдал түүнийг цэвэрлэх, зайлуулах болон зохицуулах хэлбэр:

- Хог хаягдлыг орон нутгийн нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх талаар гэрээ байгуулж, холбогдох татвар хураамжийг цаг хугацаанд төлөх

- Ангилсан хог хаягдлаас боломжтой хэсгийг хоёрдогч түүхий эдийн цэгүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тогтмол тушаана.
- Барилгын ажлыг гүйцэтгэх явцад гарах хатуу хог хаягдлыг мөн түр цуглуулах цэгийг байгуулж хамгаалалтын хашаа, бункерт хийнэ. Ингэхдээ хууль, журмын дагуу энгийн, хяналттай, аюултай шинж чанараар нь ангилж хадгална. **Үүнийг хог хаягдал тээвэрлэх, устгах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр түшааж байна.** Төслийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн хог хаягдлыг тушаасан талаарх тэмдэглэлийг тогтмол бүртгэнэ.
- Шатах тослох материалын сав, ахуйн цэвэрлэгээ, ариутгалын бодисын сав, баглаа боодлыг мөн тусад нь цуглуулна.
- Шингэн хаягдал болон бохирын асуудлыг Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын дагуу бохирыг соруулж зөөвөрлөх боломжтой байхаар зохион байгуулах
- Бохирыг соруулах, зөөвөрлөх эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажиллах.

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Биелэлтийн үр дүн
1	Агаарын чанар: Агаарын тоосны (TSP, PM_{10}, $PM_{2.5}$) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх Агаарын бохирдлын (NO_2, SO_2, CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар.	Төслийн талбайн авто зогсоол, Ухашны салхин доод талд	Тоосны хяналт: Төслийн талбайд 2 цэгт 1 удаадаа Өдөрт 2 удаа Агаарын найрлага: буюу жилд 1 удаа 8 сард	Агаарын чанарын шинжилгээний үр дүн 

2	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: pH, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO3), Ca, Mg, Na, K, SO4, NO2, NO3, NH4, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	Худаг: Унд ахуйн усыг хангаж буй гүний худгаас Хаягдлын сан	Жил бүр 8 сард	

MNAS Accreditation system TL 08-02 MNS ISO/IEC 17025

УС,ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Өвөрхангай аймаг Арвайхээр сум, Шинэ Арвайхээр, 13-р баг
Б.Рэнчинпэлжээгийн гудам, 108 тоот
Утас/Факс: 70322472, цахим шуудан: Uvurkhagngai288@gmail.com

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он № : 2025/91,92
Сорьц ирүүлсэн газрын нэр хаяг утас : ИМПЕРИО МАЙНИНГ ХХК
Дээжийг авсан хүний нэр албан тушаал : Геологич н.Нямхүү
Сорьцын тоо тоолол : Уурхайн ашиглаж буй нуурын ус -2ш, 3.0л
Сорьц авсан огноо : 2025.08.17
Сорьц хүлээн авсан огноо : 2025.08.18
Шинжилсэн огноо : 2025.08.18-2025.08.29
Хэвлэсэн огноо : 2025.09.03
Хуудасны тоо : 1/1

№	Сорилт шинжилгээний үзүүлэлтүүд	Сорилтийн аргын тэмдэглэгээ	Ерөнхий шаардлага MNS 4943:2015	Шинжилгээний дүн	
				Цэвэр нуур	Бохир нуур
1	Устөрөгчийн ион /PH/ агууламж	MNS ISO 10523-2004 ОАКТОН-610	6-9	7.17	7.36
2	Үнэр	-	Мэдрэхүй	Үнэргүй	Үнэргүй
3	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч мгО/л	MNS ISO 5815:2001	20	6.7	10.9
4	Фосфор P мг/л	MNS ISO 6878-2001	1.5	0.069	0.095
5	Нитрит NO_2 мг/л	MNS ISO 6779:2019	-	0.001	0.186
6	Нитрат NO_3 мг/л	MNS 6834:2020	-	4.93	6.18
7	Аммони NH_4 мг/л	MNS 1097:2023	-	0.01	0.09
8	Умбуур бодис мг/л	MNS ISO 6836:2020	30	13.0	110.0
9	Перманганатын исэлдэх чанар мгО/л	MNS ISO 6833:2020	20	3.4	6.4
10	Нийт азот мгN/л	MNS ISO 11083:2001	15	4.941	6.456

Шинжилгээ гүйцэтгэсэн: Инженер Б.Амартүвшин
Хянаж баталгаажуулсан: БОШЛ-ийн эрхлэгч Б.Ичинхорлоо

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй
Хуулбарлан хэрэглэхийг хориглоно

3	Хөрсний төлөв байдал, бохирдол: Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO_3, P_2O_5, K_2O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадьми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайн хог хаягдлын цэг болон ариун цэврийн байгууламжийн цэгт хөрсний хүнд металл болон эрүүл ахуйн бактерийн холимог дээж авах ШТС болон автомашиг зогсоол хөрсний хүнд металлын дээж Биологийн нөхөн сэргээлтийн дараа хөрсний агрохими	Төслийн үйл ажиллагаа дуусахаас өмнө 1 удаа, Жил бүр 8 сард	 УС,ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ Өвөрхангай аймаг Арвайхээр сум, Шинэ Арвайхээр, 13-р баг Б.Рэнчинлэхүүгийн гудам, 108 тоот Утас/Факс: 70322472, цахим шуудан: Uvurkhagngai288@gmail.com ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН Дугаар он № : 2025/3,4 Сорьц ирүүлсэн газрын нэр хаяг утас : ИМПЕРИО МАЙНИНГ ХХК Дээжийг авсан хүний нэр албан тушаал : Геологич н.Нямхүү Сорьцын тоо төрөл : Хөрсний сорьц -2ш, Сорьц авсан огноо : 2025.08.17 Сорьц хүлээн авсан огноо : 2025.08.18 Шинжилсэн огноо : 2025.09.08-2025.09.18 Хэвлэсэн огноо : 2025.09.19 Хуудасны тоо : 1/1 1.Агрохимийн шинжилгээ Шинжилгээ гүйцэтгэсэн: Инженер Б.Амартүвшин Хянаж баталгаажуулсан: БОШЛ-ийн эрхлэгч Б.Ичинхорлоо Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй Хуулбарлан хэрэглэхийг хориглоно	

Д/д	Сорьц авсан цэгийн нэр	Ялзмаг	pH	NH_4	NO_3	PO_4	SO_4
1	Хөрс-1 (45.807384,101.313431)	1.60	8.10	45.30	92.3	5.7	45.2
2	Хөрс-2 (45.808032,101.324086)	1.58	7.88	33.59	10.7	6.7	7.1
	MNS 3297.2019 / ЗДХ/	-	-	-	130	-	160

Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тухайн жилийн нийт зардлын дүн	355.0	

АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Биелэлтийн үр дүн
	1	2	3
1.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг хугацаандаа танилцуулах, батлуулах	-	2025 онд БОМТ батлуулсан. Хавсралтаар баталсан нүүрийг оруулав.
2.	Энгийн хог хаягдлын гэрээ сунгуулах	-	Сунгуулан хавсралтаар төлбөр төлсөн баримт болон гэрээг хавсаргалаа.
	Нийт	-	

АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Биелэлтийн үр дүн	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	2025 оны БОМТөлөвлөгөөг танилцуулах, батлуулах	Цаасан	Тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2025.04 сард батлуулсан	-	Гүйцэтгэх захирал	АБОГ, БОУАӨЯ
2.	2025 оны батлагдсан БОМТөлөвлөгөөг танилцуулан ажлыг эхлүүлэх	Цаасан	Ажлын жагсаалт, хугацаа, зорилтууд	2025.08 сард эхлүүлсэн	-	Гүйцэтгэх захирал	Төслийн талбай
3.	БОМТ-ны хэрэгжилтийн ажлын явцтай танилцах	Цаасан, зургаар	Байгаль орчны төлөвлөгөөнд тусгасан ажлуудын явц	2025.10 танилцсан	-	Гүйцэтгэх захирал	Аймгийн БОГ
4.	БОМТ-ний дагуу хийгдсэн ажлыг хүлээлгэн өгөх	Цаасан, зургаар	Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2025.11 сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	-	Гүйцэтгэх захирал	Аймгийн БОГ

5.	БОМТ-ны дагуу хийгдсэн ажлыг тайлагнах	Цаасан, зургаар	Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг батлуулах	2025.12 сар тайлагнана.	-	Гүйцэтгэх захирал	Аймгийн БОГ, БОУАӨЯ
	Нийт				-		

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 166.824 сая төгрөг

ХАВСРАЛТ

2025 оны БОМТ баталсан нүүр

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА — Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"ИМПЕРО МАЙНИНГ" ХХК ЗАХИРАЛ — Б.БАТЦЭЦЭГ

"ИМПЕРО МАЙНИНГ" ХХК НИЙ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ, БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИНЭ.ҮЗҮҮРТ ТАЛБАЙН "ЖАЛГА 2", "ЖАЛГА 3" АЛТНЫ ШОРООН ОРД ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-022144
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6613713

ХЯНАСАН:
ХБОБХГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ — Ц. ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН:
"ИМПЕРО МАЙНИНГ" ХХК БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН — Х.ЗУЛСАР

2025 ОН

2025 оны Аюултай хогны гэрээ

БАТЛАВ:
“ИМПЕРО МАЙНИНГ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ:
"АЛТАН ОРШИХУЙ ГРУПП" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Р.БАЯРБАТ

ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС, ТОСОЛГООНЫ ШИНГЭНИЙ ХАЯГДАЛЫГ ҮҮСГЭГЧ НЬ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ГЭРЭЭ
№

2023 оны 11-р сарын 07 -ны өдөр Улаанбаатар хот

Энэхүү Техникийн хаягдал тос, тосолгооны шингэн хаягдалыг хүлээлгэн өгөх гэрээ /цаашид **“Гэрээ”** гэх/-г нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчин гудамж, Пеарл тауэр 704 тоот хаягт байрлах **6613713** тоот регистрийн дугаар бүхий “Имперо майнинг” ХХК /цаашид “ **Үүсгэгч**” гэх/-ийг төлөөлж Ерөнхий геологи албан тушаалтай Борхүү овогтой Бүтэмж нөгөө талаас Улаанбаатар хот Багахангай дүүрэг 1-р хороо химийн гудамжинд байрлах **5537266** регистрийн дугаартай “Алтан Оршихуй Групп” ХХК /цаашид **“Боловсруулагч”** гэх/-ийг төлөөлж Хангамж, борлуулалтын менежер албан тушаалтай Д.Ариунмөрөн нар /хамтад нь **“Талууд”** гэх/ Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, байгаль орчины нөлөөлөх байдлын багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Үүсгэгч нь өөрийн үйлдвэр, уурхайгаас гарах техникийн ашигласан тос, тосол, гидрийн шингэн болон бусад тосолгооны шингэний хаягдал /цаашид **“Хаягдал тос”** гэх/-ийг холбогдох дүрэм, журмын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэн Үүсгэгчээс Боловсруулагчид шилжүүлэх, Боловсруулагч нь хүлээн авах, устгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хаягдал тос нь хог хаягдлын ангилалын төрлөөр аюултай хог хаягдлын **А** зэрэглэлд *\БОАЖЯСайдын А/349 тоот кодчилсон жагсаалтанд* багтсан байгаль орчинд хор аюулын чанартай шингэн хог хаягдал юм.

1.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ байгаль орчны бохирдол гаргахгүй, галын аюулгүй байдлыг бүрэн сахиж, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд үйл ажиллагаа явуулах шаардлагатай.

1.4. Энэхүү гэрээнд талууд нөгөө талынхаа хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нуущыг чанд хадгалах зарчмыг баримтална.

1.5. Энэхүү гэрээний Хавсралт №1-т Үүсгэгчийн хаягдал тос цуглуулах, хадгалах үйлдвэр, уурхайн жагсаалт, **сард гарах хаягдалын хэмжээ, төрлийг бүрэн тодорхойлж** хавсаргах бөгөөд энэхүү хавсралт нь гэрээний салшгүй нэгэн гол хэсэг байна.

Хоёр. Гэрээний хугацаа

Гэрээ нь 2023 оны 11-р сарын 07 -ний өдрөөс 2024 оны 11-р сарын 07 -ний өдөр хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

1.2 Гэрээний хугацааны хэрэгжилтийг хоёр тал харилцан үйл ажиллагаа зохистой явагдсаныг хянан, дүрэм журмын биелэлтийг дүгнэж, сунгах саналыг шийдвэрлэнэ.

1.3 Гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан дүгнэлтэнд дараах зүйлийн биелэлтийг дүгнэнэ. Үүнд:

1.3.1 Энэхүү гэрээний баталгаанд Үүсгэгч нь өөрийн эзэмшлийн талбай дээрх хог хаягдалын кодчилсон жагсаалтын 13-р бүлгийн аюултай хаягдалын төгрөгт тооцон жилд нийлүүлэх хаягдалаас хамааран 800.000 **“Гэрээний төлбөр”** болгож Боловсруулагчид байршуулах.

2025 оны энгийн хог хаягдлын гэрээ, сунгуулан нэмэлт хийсэн

БАТЛАВ.
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.СУГАР
2024 оны 01 сарын 05-ны өдөр

ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2024 оны 01 сарын 05 өдөр № Цагаан-Овоо

НЭГ. Нийтлэг үндэслэл

Монгол улсын байгаль хамгаалах тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн 17-р дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйлүүдийг үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллах амьдрах орчыг бий болгоход оршино.

Хоёр. Гэрээ байгуулагч талууд

Нэг талаас Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын ЗДТГ-ыг төлөөлж ЗДТГ-ын дарга Б.Сугар нөгөө талаас “Имперо майнинг” ХХК-ний гүйцэтгэх захирал Б.Батцэцэг нар харилцан тохиролцож 2024 оны 01-р сарын 01-ны өдрөөс 2024 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Төлбөр тооцсон байдал

30 хүнтэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд бэлтгэл ажил гүйцэтгэлийн хугацааг дуустал төлбөрийг тооцов.
Ажиллах хугацаа:05 сар
Жилийн төлбөр: 1.019.897төгрөг

Дөрөв. Сумын ЗДТГ-ын эрх үүрэг

- Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих.
- Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах

Тав. Аж ахуй нэгжийн эрх үүрэг

Галын дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0013152

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: “Мөнгөрөө майнинг” ХХК

Хаяг Өвөрхангай Нарийн тээл сум 11 баг /үсгээр/
гудас гавар

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: Ажилчдын зөөврийн
орон сууц, гал тогооны зориулалттай

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/
/Улсын төмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Олгосон 2023 он 11 сар 15 өдөр

Хүчинтэй хугацаа 2025 он 11 сар 15 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

Өвөрхангай аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга ахлагч хурандаа цолтой Д. Одгэрэл

Дүгнэлт гаргасан:

Өвөрхангай аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч: ахлагч цолтой Б. Баянхонгор

/тэмдэг дарна/

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0006759

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: “Шинэро майнинг” ХХК

Хаяг: Өвөрхангай Нарийнтээл сум II баг /үзүүрт/ газар

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: нүүлгэлт

тээвэр, зангилан боруулалт

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2/
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Олгосон 2023 он 11 сар 15 өдөр

Хүчинтэй хугацаа 2025 он 11 сар 15 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон ГАМШГАЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ 034

Өвөрхангай аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга ахлах хурандаа цолтой Ж. Одонбаяр

Дүгнэлт гаргасан:

Өвөрхангай аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахлах цолтой Б. Баянжаргал

ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ 052

/тэмдэг дарна/

2025 оны хогны төлбөр төлсөн баримт